

Телеки Кристина(Ph.D)

Унгар улс

Түлхүүр үгс: Монголын шарын шашин, Цагаан сар, Лхам бурхан, Цэдэрлхамын хурал, данраг тахил, Зүүн хүрээ Дашчойлин хийд, Позднеев, сурвалж бичиг, IV-дүгээр Банчин лам, Цагаан човомбо

Гол утга: Тус өгүүллэгт шинэ жилийн ачлал тахил буюу битүүний шөнөөр Лхам бурханд (Охин тэнгэр, Балдан Лхам, тө. dpal ldan lha mo) зориулсан Цэдэрлхам (тө. tshes gtor lha mo) хурлын хүрээнд Монголын сүм хийдүүдэд өргөх Данраг (тө. gtang rag) тахилыг танилцуулна. Данрагын нэр, төрлүүд, Цэдэрийн данраг өргөх үйл явцыг шалгаж, тахилын хэсгүүд болон түвд, монгол сударт буй хэсгүүдийг орчуулж Данраг тахил нь тус тахилын зүйлүүдийг бурханд ачлал дамжуулахаас гадна шинэ жилдээ шашныг хамгаалах, сайн сайхан бүхэн дэлгэрч байхыг бэлэгдсэн бэлэгдлийн утга санаатай. Шалгасан төвд судруудын дагуу Лхам бурхны энэ тахилга бол IV Банчин лам Лувсанчойжисжалцан (1570-1662) зохион бичсэн бололтой.

Өвлийн адаг сарын 30 буюу битүүний дүйцэн хурлыг сүм хийдүүдэд хурдаг уламжлалтай. Битүүний шөнөөс шинийн нэгний өглөө хүртэл лам нар Лхам бурханд (Охин тэнгэр, Балдан Лхам, тө. dpal ldan lha mo, санс. Śrīdevī) зориулсан Цэдэрлхам (тө. Tsedor Lhamo, тө. tshes gtor lha mo)²⁶⁹ хэмээх онцгой Сахиус хурлыг хурдаг.²⁷⁰ Тус хурлын гол утга санаа нь битүүний шөнө Лхам бурхан Мулэдинг (тө. mu le dings) нууран дахь оронгоосоо өөрийн луусаа хөлөглөн 3 мянган ертөнцийг тойрч Монголд түр саатан морилдог хэмээн үздэг. Дээр үед дуганы голд лам нар үнс асгаж, үнсэнд луусын туурайны мөр үлдэх хүртэл буюу Лхам бурхныг биеэрээ морилон иртэл хурал хурдаг байжээ. Одоо монголчууд үүднийнхээ тотгонд 3 хэсэг мөс, алтан харгана тавьдаг уламжлалтай. Энэ нь Лхам бурхны унаа болох луусыг ундаалах мөс, дагаж ирэх буг чөтгөрийг зайлуулах зан үйл юм. Хийдэд үүрээр лам нар Лхам бурхны ачлал тахил (данраг) өргөж, ирэх жил сайн сайхан байлгахыг Лхам бурхнаас хүсэн залбирдаг. Их хэлмэгдүүлэлтээс өмнө битүүнд Цэдэрлхамын хурлыг зарим нэгэн жижиг сүм дугануудад хурдаггүй байсныг эс тооцвоос хүрээ хийд болгонд хурдаг байлаа. Эдүгээ энэ ёсыг дахин сэргээн монголд үйл ажиллагаа явуулж байгаа бараг бүхий л сүм хийдүүд хурах болсон.

²⁶⁹ Төвд хэлээр Цэдор, харин монголчууд Цэдэр хэмээн нэрлэж заншсан.

²⁷⁰ Тус өгүүллэг нь Улаанбаатар хот дахь Зүүн хүрээ Дашчойлин хийдэд хурсан хурал дээр харсан зүйлсийг танилцуулах болно.

Тус өгүүллэгт данрагын нэр, төрлүүд, Цэдэрийн данраг өргөх үйл явц, тахилын хэсгүүд болон түвд, монгол сударт буй хэсгүүдийг танилцуулна.²⁷¹

Данрагын нэр, эх сурвалжууд

Данраг²⁷² (тө. *gtang rag*, санс. *subharman*; данраг дором, тө. *gtang rag gtor ma*; ачлах тахил, мо. *ačilal*, *ačilaqu takil*; ачлах балин, мо. *ačilaqu baling*, тө. *gtang rag gtor ma*)²⁷³ тахилын гол зорилго нь бурхад буюу сахиусуудад талархалаа илэрхийлж, тэдгээрийг тангарагаа гүйцэтгэхийг хүсэмжлэх ба шашныг сахин хамгаалахыг гуйж айлтгадаг учиртай. Ачлал нь олон янз байна. Ер нь ачлал тахил нь тустай тахилын ширээн дээр гурван балин,²⁷⁴ тэдгээрийн эргэн тойрон тавьсан зүйлүүдээс бүрдэнэ.

Позднеев ХІХ зууны сүүлд Монголд данраг тахилыг хэрхэн хийдэг тухай товчхон танилцуулахаас гадна гараар зурж үлдээсэн байна.²⁷⁵ Түүний бичиж тэмдэглэсэнээр энэ гурван балин нь Догшидын хуралтай (буюу Сахиусны хурал) холбоотой.²⁷⁶

Позднеевийн бичсэнээр лам нар балинг хийхэд гарын авлагыг ашиглаж байсан.²⁷⁷ Одоогийн човомбо (тө. *mchod dpon*) тахилч нар Цагаан човомбо Лувсаннамжилын (тө. *blo bzang nam rgyal*) тахилуудын тухай төвд хэлээр зурган тайлбартай бүтээсэн номыг ашиглаж байна. Тэрхүү номонд данрагын олон янзын зургуудыг зурсан байдаг.²⁷⁸ Эдгээр гурван балин бол янз бүрийн данрагын хэсгүүд, мөн эргэн тойрон тавьсан тахилууд өөр өөр байна.

Данрагын төрлүүд

²⁷¹ Уг судалгааг Унгар улсын ОТКА PD 83465 ивээн тэтгэсэн. Данрагын тахилын тухай дэлгэрэнгүй зохиолууд: Majer Zs., *A Comparative Study of the Ceremonial Practice in Present-day Mongolian Monasteries*, PhD dissertation, ELTE University, Budapest 2008, pp. 68-72.; Majer Zs. - Teleki K., *Mongol-tibeti halaado aldozat (danrag) a haragvo istensegeknek*. In: Birtalan A., Kelenyi B., Szilagyi Zs. (szerk), *Oseink nyoman Belso-Azsiaban IV, Vedelmezo Istensegek es demonok Mongoliaban es Tibetben*. L'Harmattan, Budapest 2010, pp. 39-63.

²⁷² Төвд хэлээр данраг, харин даараг хэмээн ч нэрлэж заншсан.

²⁷³ Majer-Teleki, p. 40.: *Das, Sarat Chandra: A Tibetan-English Dictionary*. Calcutta 2000/1902, p. 520. „thank, thanksgiving and prob. also thank-offering, esp. rendering thanks to a deity”. *dGe bshes Chos kyi grags pas brtsam pa'i brda dag ming tshig gsal ba bzhugs so. Mi rigs dpe skun khang*, Peking. 1987, p. 335; *phyir phebs pa'i dga' ston mchod pa'am bka' drin gyi 'bul ba'*; *Sumatiratna: Bod hor gyi brda yig ming tshig don gsum gsal bar byed pa'i mun sel sgron me*. (*Corpus Scriptorum Mongolorum VI, VII.*). Ulaanbaatar 1959.; Kowalewski, Joseph Étienne: *Dictionnaire mongol-russe-français*. Kazan 1844, 1846, 1849, p. 120.; *Sumatiratna: Bod hor gyi brda yi*. p. 819.; Pozdneyev, Aleksei Matveevich: *Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia*. Ed. Krueger, John R. *The Mongolia Society*, Bloomington 1978, p. 379.

²⁷⁴ Балин (санс. *bali*) буюу дором (мө. *gtor*) буюу торво/дорбо (мө. *gtor pud*, *gtor phud*).

²⁷⁵ Pozdneyev: *Religion and Ritual*. pp. 379, 417-443; p. 422., pp. 426-430,

²⁷⁶ Pozdneyev: *Religion and Ritual*. p. 379: зуны тэргүүн сарын шинийн 15-нд Бурхан багшийн дүйцэн өдрөөр (Зуны тэргүүн сарын шинийн 15-нд Бурхан багш мэндэлсэн хийгээд илт туулсан Бурхны хутгийг олсон, нирваан дүрийг үзүүлсэн их дүйцэн өдөр (мө. *mngon par byang chub pa'i dus chen*) Балдан Лхам догшидод зориулсан ачлах балинг өргөдөг (мо. *ačilaqu baling*, мө. *gtang rag gtor ma*) хэмээн бичжээ. Учир нь Балдан Лхам энэ өдөр хорвоогоос өнгөрсөн.

²⁷⁷ Pozdneyev: *Religion and Ritual*. p. 426.

²⁷⁸ *Bla ma yi dam rdo rje chos skyong rnams kyi gtor ma'i dpe ris sna tshogs bzhugs so*. (Дараа нь: *gtor ma'i dpe ris sna tshogs*)

Зүүн хүрээ Дашчойлин хийдэд ер нь гурван янзын данрагыг (Жайв данраг, Чойжоогын данраг, Цэдэрийн данраг) өргөдөг хэдий боловч бүгд төсөөтэй.

Жайв данрагыг (тө. *gyas pa gtang rag*, дэлгэрэнгүй данраг) Балдан Лхамтай холбоотой (Лхам янтай, тө. *dbyangs*, „уянга”)²⁷⁹ Сахиусны хурлын сүүлд 10 хангалд²⁸⁰ жилдээ 4 удаа өргөдөг. Хавар, зун болон намрын сүүл сарын 29., өвлийн дунд сарын 29-нд тус тус гардаг байна. Бусад Сахиусны хурлуудад Дүйва (тө. *bsdus pa*, хураангуй данраг) буюу Аваг (тө. *sngags pa*) данрагыг лам нар дотоод сэтгэлдээ урин залдаг.

Чойжоогын данраг / Чойжилын данраг (тө. *chos rgyal gyi gtang rag*)-ыг хийдэд жилд 2 удаа өргөдөг. Зуны Цам (тө. *'cham(s)*) бүжиг (зуны адаг сарын 9.) болон өвлийн хуучин хурлуудаас өвлийн адаг сарын 29-ний Сахиусны хурлын (Чойжоо янтай) эцэст өргөнө. Хоёул Чойжоо бурхан, Чойжоо дүгжүү (тө. *chos rgyal gyi drug bcu*) ба Сор залах (тө. *zor 'phen*) хэмээх галын тахилгатай холбоотой. Чойжоо дүгжүү болон Сор залах нь хамаг муу муухай ад тотгорыг арилгаж, гадна ба дотны дайсанг ялан дийлэхийн бэлэгдэлтэй зан үйл юм. Сорыг хийдийн ойрхон буй сорын овоохойд шатаагаад буцаж лам нар ирээд Чойжоод данрагыг өргөнө. Чойжоогын данрагын тахилууд нь Жайв данрагтай адилхан. 3 балин нь Жайв данрагаас арай багахан, балингын чимэглэл нь өөр. Чойжоогын данрагыг Амарбаясгалант хийд, Булган аймгийн Дашчойнхорлин хийдүүдэд Цамын үеэр өргөдөг. Түүнээс гадна Сор залах сүм хийдүүдэд өргөх боломжтой.²⁸¹

Цэдэрийн данраг (тө. *tshes gtor gyi gtang rag*) бол Жайв данрагтай төсөөтэй. Гэвч битүүнд Балдан Лхамд зориулсан тахил болой. Цэдэрийн данрагын тахилууд нь Жайв данрагтай адилхан. Энэ 3 балингууд Жайв данрагын 3 балингаас томоохон хэмжээтэй.

Өөр төрлийн данрагууд нь Лувсаннамжилын номноос данрагын тахилын өөр өөр янзын данрагууд байсан нь тодорхой байдаг.²⁸² Боржигины Баруун Чойр хийдийн данраг тахилын зурагнаас²⁸³ үзвэл энэ тахилыг хөдөөний сүм хийдүүдийн зарим нь сэргээж чадсанг харуулж байна. Гүнгаачойлин дацангийн гол сахиус Балдан Лхам Их Сахиусыг хоёр хоногын

²⁷⁹ Төвд хэлээр ян, харин яам хэмээн ч нэрлэж заншсан.

²⁸⁰ тө. *chos skyong, drag gshed*. Монголын Арван хангал, Арван сахиус (тө. *sprung ma*, санс. *pālā*), арван догшид (тө. *drag gshed*, санс. *rādra*). 10 сахиус нь: Гомбо (тө. *ngon po*, санс. *Mahākāla*, буюу Махагал, Их хар), Гонгор (тө. *ngon dkar*, санс. *Sitamāhākāla*, буюу Цагаан Махагал), Чойжоо/Чойжил (тө. *chos rgyal*, санс. *Yama*, буюу Эрлэг/Эрлиг номун хаан), Лхам буюу Балдан Лхам (тө. *lha mo, dpal ldan lha mo*, санс. *Śrīdevī*, буюу Охин Тэнгэр), Намсрай (тө. *rnam sras*, санс. *Kuvera/ Vaiśravaṇa*, буюу Бис(а)ман Тэнгэр), Жамсран (тө. *lcam sring, Beg tse*, буюу Улаан сахиус, Бэгз), Цамба буюу Цанба (тө. *tshangs pa*, санс. *Brahmā* буюу Эсрү Тэнгэр), Жигжэд (тө. *'jigs byed*, санс. *Yāmāntaka*, буюу Ямандаг), Очирваань/Вачирваань (тө. *phyag rdor*, санс. *Vajrapāṇi*), Шалиу буюу Шалиу (тө. *zhal bzhi*). Сүм хийдүүд өөр өөрсдийн гол сахиусуудтай.

²⁸¹ Чойжоо гол сахиустай хийдүүд Чойжоо данрагыг хурдаг байж болох юм.

²⁸² *gtor ma 'i dpe ris sna tshogs bzhugs so: bla ma 'i gtang rag* (p. 3.), *tshe gtor gtang rag* (p. 20.), *dam can rdo rje legs pa 'i gtang rag* (p. 23.), *zhang blon rdo rje bdud 'bul gyi gtang rag* (p. 23.), *rgyal chen rnam sras kyi gtang rag* (p. 24.).

²⁸³ Сэрээтэр, Р.: Дагинасыг баясгагч дунгийн эгшиг. Улаанбаатар 2002, хуудас. 50. Дундговь аймаг Цагаандэлгэр сум.

турш хурдаг. Их сахиусыг тахисны эцэст нь данраг өргөдөг байна. Мөн үүнээс гадна Намсрайн данраг, Жамсрангийн данраг зэргийг зарим нэгэн сүм хийдүүдэд өргөдөг.

Цэдэрлхамын хурал ба данраг өргөх үйл явц²⁸⁴

Хийдийн ихэнхи лам нар энэ шөнө шар өнгийн дээл өмсөж, харангын дуунаар (тө. 'khar nga) цуглана. Тахилын ширээн дээр Цэдэрлхамын гурван янзын балин байх бөгөөд өөр хоорондоо чимэглэл нь ялгаатай (дайдор, бэвдор, гандар).²⁸⁵ Эхлээд Жигжид Лха Жү сүм уншаад (тө. 'jigs byed lha bcu gsum; дагжид, Т. bdag bskyed, өөрийгөө төрүүлэхийн бясалгал) түр завсарлана. Дараа нь Лхам бурхны судрыг уншина.²⁸⁶ Лхам бурхны судрыг эхлээд Өндөр гэгээн Занабазар(1635-1723)-ын тогтоосон хуучин янгаар уншиж, үүрээр Лхам бурханд Цэдэрийн данрагыг өргөх уншлагыг V дугаар Богд(1815-1841)-ын тогтоосон шинэ янгаар уншдаг.²⁸⁷

Хурлын турш хэрэглэх хөгжимын зэмсэг: Хэнгэрэг/хэнгэргэ(н) (тө. nga), бороодон, цан (тө. zangs буюу sbug chol/sbub chal²⁸⁸), дохиур (тө. nga yog/dbyug), сэлнэн (тө. sil snyan), хонх (тө. dril bu), дамар (тө. da ma ru, nga chung, sang te'u/cang sang te'u, phev rdob/rdog, санс. damaru), хоёр бишгүүр (тө. gling bu), хоёр ганлин (тө. rkang gling), хоёр үхэр бүрээ (тө. chos dung).

Балин хийж, тахил тавих нь човомбо болон тахилч нарын үүрэг. Данраг өргөхийн өмнө хийдийн дотор хоёр тахилын ширээнд идээ тахилуудыг өрж тавина. Том ширээн дээр данрагын тахил (хойно дэлгэрэнгүй бичсэн байгаа), өмнө нь арай жижиг ширээн дээр ууц буюу хонины бүхэл мах, мөн дугуй тавганд сахиусанд зориулж боов боорцог, чихэр жимс тавьж, мөн манз (тө. mang ja), бэрээс (тө. 'bras zas), жижиг савхан хувинтай айраг тус бүрийг эгнүүлж засна. Энэ идээ нь цогчидын идээ буюу данрагын идээ юм. Бас нийт бусын тахил (тө. thun mong ma yin pa) нь өвөлын сүүл сарын битүүний Цэдэрлхамд гурилаар хонь хийж өргөдөг байна.

Тахилын ширээнд тахилгуудыг сайхан засаж бэлтгэсний дараа шамнах лам (тө. bshams) нь тахилуудын дэргэд бурхандаа 3 удаа мөргөнө. Түүний дараа балингуудыг гүш(а) өвсөө рашаанд дүрж цацаж ариусгана. Балин тахилыг хиргүй ариун байлгахын үүднээс шамнах лам, тахилч лам нар бүгд амны хаалт зүүсэн байна. Балингуудыг рашаанаар ариусгасны дараа таван өнгийн хадгаар буюу явдараар (тө. g yab dar) хурлын ламдах лам

²⁸⁴ Зүүн хүрээ Дашичойлин хийдэд хурсан хурал дээр харсан зүйлсийг танилцуулах болно.

²⁸⁵ Төвдөөр эдгээр нэрүүдийг хэрхэн галиглан бичих нь тодорхойгүй.

²⁸⁶ Уншдаг судар нь: 'dod khams dbang phyug dpal ldan lha mo la tshes gtor 'bul ba'i 'don cho-ga bzhug-so' (32 folios) ba lo gsar kyi tshes gtor gtang rag rgyas ba 'bul tshul dpal ldan lha mo'i dga' ston rol pa'i rgya mtsho zhes bya ba bhugs so (22 folios). Majer, *A Comparative Study*, p. 130.

²⁸⁷ Majer, *A Comparative Study*, p. 130.

²⁸⁸ Kowalewski: *Dictionnaire*. p. 2078. Das: p. 937.

Лхам бурхныг зална, харин лам нар гадаад тахилыг²⁸⁹ дотоод сэтгэлдээ оршоож байна хэмээн залбирна.

Хурал хурж байх явцад нэг удаа лам нар бүгд жавдан дээрээ зогсож, бурхдад хадгаа өргөх хооронд лам нар ая дантай уншлага уншина. Лам нар судраас тахилга өргөх хэсгийг уншихад, шамнах лам тахилуудыг нэг нэгээр өргөнө. Лам нар уг тахилын нэрийг уншихад, шамнах лам уг балинг гар дээрээ өргөн туслагч нартаа өгнө. Туслах тахилч нар балинд хүж хатгаж гаргана. Тэр нь балинд тотгор гархаас хамгаалж байна. Тэдгээр туслагч нар тахилуудыг нэг нэгээр хийдийн хаалганы өмнө хаалганаас зүүн өмнө зүгт тавьсан ширээн дээр аваачиж тавина. Дотор зассантай адилаар засаж, гадаа нар мандах үед зарим хөгжмийн зэмсэг (дун, бишгүүр, сэлнэн)-тэй лам нар тус тахилыг өргөх зан үйлийн уншлага уншина. Гадаах тахилын зан үйл гүйцэтгэсний дараа тахилгын зүйлсийг буцаан хийдэд оруулж, Замбутивын шалсай болон Дэршигийн балинг²⁹⁰ хувааж сахиусны данрагын идээтэй лам нарт хувааж хувь хүртээнэ. Данрагын балингаас Шатагыг хурлын дараа шатаана.

Мяндаг тушаалтай 4 лам (хамба, цорж, ловон, унзад) мандал өргөсний хойно 8 лам хоёр хоёроороо ном хаялцана. Үүний дараа золголт эхэлнэ. Лам нар хадаг барьж эхлээд хамба лам, цорж, ловон, гэсгүй, унзад, өндөр настай лам нартай, дараа нь өөрийн багш нарт, түүний хойно өөр хоорондоо золгоцгооно. Үүний дараа энгийн иргэд лам нартай золгоно. Золголт дуусаад лам нар тарах бөгөөд, харин 9 цагаас Цогчин хурна.

Данраг тахилын хэсгүүд

1. Тахилын 3 гол балин нь:²⁹¹

- Дэршиг, тө. 'dir gshegs rgyan gyi gtor ma/'dir gshegs rgyan gtor²⁹²/gdir gshigs²⁹³/'dir gshigs²⁹⁴, мо. ende ireged čimegen-tū baling, — „энд ирээд чимэгт балин”

10 жижиг балин тойрсон гурвалжин улаан өнгөтэй том балин юм.²⁹⁵ Позднеевийн тэмдэглэснээр:²⁹⁶ „Догшидад зориулсан гурвалжин пирамид шиг балин. Өнгө нь ямар бурханд зориулсанаас хамаардаг. Орой дээр нар, саран тэмдэгтэй, буланд асах гал, талуудад цэцгүүд. Дунд нь уг бурхны зүрхэн тарнийн үсгийг бичдэг. Үүнийг тойрсон

²⁸⁹ тө. *phyi mchod*, санс. *kandanarjā*, Үүний хэсгүүд нь: тавиг ус (тө. *mchod yon*, санс. *argham*), өлмийн сэрүүцэл/сэрүүцлэг (тө. *zhabs gsil*, санс. *radyat*), цэцэг (тө. *me tog*, санс. *piāpe*), утах хүж (тө. *bdug spos/dri bzang*, санс. *dhūpe*), зул (тө. *mar me*, санс. *aloke*), үнэрт ус (тө. *dri chab*, санс. *gandhe*), гэгээний зоог (тө. *zhal zas*, санс. *naividū*). Эдгээрийг гүнгэрвааний долоон цөгц агуулдаг (тө. *nyer spyod bdun/nyer mchod bdun*).

²⁹⁰ „Данраг тахилын хэсгүүд” хэсгээс үзнэ үү.

²⁹¹ *Majer, A Comparative Study*, pp. 69-72.; *Majer-Teleki*, 53-56. Тахилыг Зүүн хүрээ Дашичойлин хийдэд харсан ба Лувсаннамжилын зургаар танилцуулж, Позднеевийн бичиж тэмдэглэсэн зүйлсийг ашиглав. Нэр томъёонуудыг нарийвчлан тогтоохын тулд өгүүлэгийн эцэст байгаа төвд ном судруудыг үзэв. Гэрэл зургуудаас үзнэ үү.

²⁹² *gtor ma'i dpe ris sna tshogs*. p. 16.

²⁹³ *gtor ma'i dpe ris sna tshogs*. p. 24.

²⁹⁴ *gtor ma'i dpe ris sna tshogs*. p. 24.

²⁹⁵ *gtor ma'i dpe ris sna tshogs*. p. 16. 'dir gshegs rgyan gtor/ zur gsum dmar po/ 'khor zur gsum bcus bskor-ba/

²⁹⁶ *Pozdnev, Religion and Ritual*. p. 427.

олон жижиг балингууд бол уг бурхны нөхрийг тэмдэглэнэ (санс. mitra, буюу barišad, тө. 'khor ba буюу grogs, санс. par(i)ḥad/parivāra).”

- Шатаг, тө. sha khrag (dmar gyi/ mar gyi) gtor ma бол улаан мах цусны балин (мо. miq-a čisun-u baling, miq-a čisun-u ulayan baling)

Гурвалжин улаан балингийн орой нь шовх.²⁹⁷ Позднеевийн тэмдэглэснээр:²⁹⁸ „онц балин бол пирамид шиг чимэггүй бор өнгөтэй балин. Балингийн суурин дахь эрхтэнүүдэд: хөл, гар, хэл, тархи зэрэг тэмдэгүүд. Энэ балинг хурлын дараа шатаах буюу хаяна. Нөгөө хоёр балинг харин дуган дотор үлдээж болох буюу лам нарт тараана.”

- Замбутивийн шалсай,²⁹⁹ мо. jambutib-un šalsai, тө. 'dzam bu'i gling gi zhal zas/dzam bu ti ba'i zhal zas,³⁰⁰ мо. dzambudvib-un idegen – „замбутивийн идээ”.

Бөөрөнхий, цагаан өнгөтэй балин.³⁰¹ Позднеевийн³⁰² бичснээр: „энэ балинг газрын эздэд зориулна. Жуувгар балин, орой дээр нь нар, сар, хүслийг хангагч чандмань эрдэнийн улаан, шар ба 5 өнгийн тэмдэгтэй. Талууд нь янз янзын өнгө бүхий цэцгүүдийн чимэгтэй.”

2. Гурван балингийн дэргэд дараахи тахилууд байна:

- чан, тө. chang — „пив”, тахилын архи
- ус, мо. usun, тө. chu – усан тахил
- нанчид, мо. nangčid, nangčod,³⁰³ тө. nang mchod — „дотрын тахил”, тахилын архи
- гурван балингийн дэргэд нэг арай бага балин байна: Шавдаг дором, мо. šibday durm-a/duurm-a/durum-a, тө. gzhi bdag(gi) gtor(ma) — „лус савдагуудын балин”. Энэ нь бор өнгөтэй 4 чимэгтэй балин юм.

3. Энэ тахилуудын өмнө зэрэгцээ доорхи тахилууд оршино:

- манраг³⁰⁴/манхаг³⁰⁵/манх³⁰⁶/ мо. mangday, тө. sman rag³⁰⁷/sman raḥpa³⁰⁸/sman khug,³⁰⁹ мо. rakta-yin em-ün takil — „ракта-гийн эмийн тахил”, нэг цөгцөнд, жижиг уутанд тавьсан тахилга (эмийн ургамал, үр, жимс, 9 эрдэнэ).

²⁹⁷ gtor ma'i dpe ris sna tshogs. p. 16. sha khrag dmar gyi gtor ma/ zur gsum dmar po/ rtse mo rno ba/

²⁹⁸ Pozdneyev, *Religion and Ritual*. pp. 427–428.

²⁹⁹ Аль эсвэл замбатив, мо. zambutib, замбуулин, мо. zambuling

³⁰⁰ gtor ma'i dpe ris sna tshogs. p. 16.

³⁰¹ gtor ma'i dpe ris sna tshogs. p. 16. dzam bu ti -ba'i zhal zas/ zlum gtor dkar po yin no/

³⁰² Pozdneyev, *Religion and Ritual*. pp. 426–427.

³⁰³ Сүхбаатар, *Хар үгийн толь*. p. 146.

³⁰⁴ Зүүн хүрээ Дашичойлин хийдийн лам нараас тэмдэглэсэн тэмдэглэлээс

³⁰⁵ Сүхбаатар, *Хар үгийн толь*. p. 133.

³⁰⁶ Сүхбаатар, *Хар үгийн толь*. p. 133.

- загад,³¹⁰ тө. *dza khad/gad dra' po sman*,³¹¹ мо. *dzagad bayatur em-ün takil* — загад баатар эмийн тахил – цөгцөнд тавьсан цагаан будаа. загад баатар тахилга нь: цөгцөнд эмийн журмаар хэрэглэдэг архи³¹²
- сэржим, мо. *serjim*, тө. *gser skyems*, мо. *ariyun altan darasun* — ариун алтан дарс, тахилын архи.³¹³
- чимар, мо. *čimar*³¹⁴, тө. *phye mar* — арвайн гурил шар тосыг холисон жижиг овоолсон балинг 3 том балингийн дэргэд нэг цөгцөнд хийж тавина.
- гүш(а) (өвс), мо. *kuša/guša/gūša*, тө. *ku sha*, санс. *kuša* — балинг сагнах хэрэглэдэг өвс

4. Балингийн өмнө ламын тахил (мо. *blam-a/lama-yin takil*, тө. *bla ma mchod pa* буюу дөрвөн устай ойрын тахил, тө. *chu gzhi nyer spyod*^{315,316}) ба бойпор (тө. *spos phog*, үнэртэн шатаах сав).

Данрагтай холбоотой түвд, монгол зарим судар

Данрагын тахилын судар олон янз байдаг. Унгар Улсын Шинжлэх Ухааны Академи (МТА) Дорно Дахины Судлалын Номын Сангаас данраг тахилгын Балдан Лхам (*dmag zog rgyal mo*) бурхны дөрвөн судар хайж олсон. Түүнтэй холбоотой төвд хэл дээрх 3 судрын доторхи данрагын хэсгүүд Лувсаннамжил ламын зохиолтой адилхан байна. Харин монгол хэл дээрх 1 судар Балдан Лхамын бүтээх аргын (дүбтав, тө. *sgrub thabs*, санс. *sādhana*) судар мөн хэмээн үзэж байна.

1. II-дугаар далай лам Гэндэнжамцийн (1475-1542) зохиосон „*Dod khams dbang phyug ma dmag zor rgyal mo'i sgrub thabs gtor chog bzhugs so*” Балдан Лхам бурхны дүбтав (МТА 21.)³¹⁷ II-дугаар далай ламын зохиосон Лхам бурхны дүмта IV-дүгээр Банчин лам Лувсанчойжижалцан (1570-1662) үргэлжлүүлэн нэмж зохион бичсэн.

³⁰⁷ *sman rag gtor ma*-гийн тухай *Nebesky-Wojkowitz (Oracles and Demons. p. 199.)* эмийн ургамал ба цусны халимаг хэмээн тэмдэглэсэн. *Nebesky-Wojkowitz* бас нэг олон янзын эмнээс бүтсэн *sman gtor* нэртэй өөр балинг ч тэмдэглэнэ үлдээсэн (p. 199.). Уг хоёр балинг оточ Маналд (тө. *sman bla*) өргөдөг хэмээн бичжээ.

³⁰⁸ *gtor ma'i dpe ris sna tshogs. p. 16.*

³⁰⁹ Сүхбаатар, Хар үгийн толь. p. 133. (эмийн уут)

³¹⁰ Зүүн хүрээ Дашичойлин хийдийн лам нараас тэмдэглэсэн тэмдэглэлээс

³¹¹ төвд сударт: *dza gad dra' bo'i sman phud.*

³¹² *Chos kyi grags pa. p. 718. dra' bo'i khyad par can gyi sha'i phud dam chang ngam chang rgod la sman btap pa'ang zer/*

³¹³ Сэрчим - Диваажингийн рашааныг бэлэгдсэн тахилын ундаа

³¹⁴ Сүхбаатар, Хар үгийн толь. p. 212. буруугаар *phyi mar* бичсэн

³¹⁵ *gtor ma'i dpe ris sna tshogs. p. 16.*

³¹⁶ Гадаад тахилтай адилхан. Гэхдээ түрүүн тавиг ус (мо. *tabiy usun*, тө. *mchod yon/yon chab*, санс. *argham/arghya*) ба ариулан цацахын ус (мо. *ariyulan sačiqu-yin usun*, тө. *gsang gtor/chu 'thor ba*, санс. *prokāāōa*) зэргийг нэмнэ.

³¹⁷ *Terjek, Jozsef.: Collection of Tibetan MSS and Xylographs of Alexander Csoma de Koros. MTA, Budapest 1976. p. 71. Мөн: A Catalogue of the Tohoku University Collection of the Tibetan Works on Buddhism. Ed. Kanakura, Yensho – Yamada, R. – Tada, Tan. – Hadano, H. Sendai 1953. No. 5577/1; Schmidt, Isaac Jakob – Bothlingk, Otto von: Verzeichniss der tibetischen Handschriften und Holzdrucke im Asiatischen Museum der Kaiserlichen Akademie der Wissenschaften. (Bulletin historicophilologique de l'Académie Impériale des Sciences de St. Pétersbourg 4) Tome V.*

2. rGyas pa'i gtang rag 'bul ba'i tshul bzhugs (цаашид: rGyas pa) (Tib. 532/7, 1a-4b) 10 хангалд зориулсан жайв данрагыг танилцуулна (4b).

3. Na mo guru/ Lo gsar gyi tshes gcig la dpal ldan lha mo la mchod gtor rten rdzas 'bul bar 'dod pas, (цаашид: Lo gsar, 51b-56a), (Tib. 525 /32.,) гэсэн судрын хэсэг (54b-55b) бол шинэ жилтэй холбоотой данрагыг танилцуулна.

4. Ямандаг, Махагал, Эрлэг хаан, Охин тэнгэр дөрвөн догшин судар хэмээх монгол судар бол Балдан Лхамын бүтээх аргыг танилцуулж (МТА, 81, Yamandaga Maqagala Erlig qayan Ōkin tngri dörben doysin sudur-un orosiba)³¹⁸ эцэст нь ачлал тахилыг бичнэ. (31a–31b).

Энэ дөрвөн судрын галиг ба орчуулга

ВНУОН (...) chos dbyings dbang phyug ma gcig bdud kyi yum/ zhes pa nas/
 bya khyi ce sbyang la sogs 'khor dang bcas/³¹⁹
 tshe ring mched lnga bstan ma bcu gnyis dang/
 yul lha gzhi bdag gnyan po 'khor dang bcas/
 dgra bo³²⁰ srog la dbang byed bshan pa'i tshogs/
 'dir gshegs rgyan gyi gtor ma 'di bzhes shig/
 ches pa 'di nas gtor ma byang shar gyi mtshams su gshegs/³²¹
 sha khrag dmar gyi gtor ma 'di bzhes shig/
 'dzam bu ti ba'i zhal zas 'di bzhes shig/
 sman rag phud kyi mchod pa 'di bzhes shig /

 dza gad dpa' bo³²²,i sman phud 'di bzhes shig /
 gtsang ma phud kyi gser skyems 'di bzhes shig /³²³
 sngar bcol legs pa'i gtang rag gnyan por gtong/
 da 'chol³²⁴ legs pa'i gsol 'debs gnyan por bzhes/
 'khor rnams skyong zhing rkyen rnams bzlog pa dang/
 sdang ba'i dgra dang gnod pa'i bgegs la sogs/
 bdud dang bar du gcod pa nam mang po/

1847, pp. 145–151. No. 343/4; Taube, Manfred: *Tibetische Handschriften und Blockdrucke I–IV. (Verzeichniss der orientalischen Handschriften in Deutschland XI/1–4)* Wiesbaden 1966, No. 880–883.

³¹⁸ Yamandaga Maqagala Erlig qayan Ōkin tngri dörben doysin sudur-un orosiba: МТАК. Mong. 81.; Kara Gyorgy: *The Mongol and Manchu Manuscripts and Blockprints of the Hungarian Academy of Sciences. Bibliotheca Orientalis Hungarica XLVII. Akadémiai Kiadó, Budapest 2000. pp. 116-120., 92a-125b*

³¹⁹ Lo gsar, 54b. дараагийн мөр нь: ma gcig dpal gyi lha mo 'khor dang bcas

³²⁰ Lo gsar, 54b. drag po'i

³²¹ Lo gsar, Rgyas pa: энэ мөр алга байна

³²² dba' bo

³²³ rGyas pa, 4a: gtsang ma'i phud kyis gser skyems

³²⁴ Lo gsar, 55a., rGyas pa, 4r: da bcol

thams cad rdul phran bzhin du brlag pa dang/
bstan pa rgyas pa'i las 'di khyod kyis sgrubs/ (...)

ВНУОН

(...) nom-un činar-un erketei γαϥčakú simnus-un eke: kemekú-i-eče:

noqai činu-a sibayun terigúten nókód-lúge nigen-e:

urtu nasutai tabun egeči dúi³²⁵ saγuritai arban qoyar ókin tngri³²⁶ kiged:

orod delekei-yin efen doγsin nókód nigen-e:

dayisun-u amin-i erke-ber bolγaγči yaračin-un ayimaγ:

ende ireged čimeg-tú ene baling-i amsan soyurq-a:

kemekú-i ber baling-i ende-eče umar-a doron-a-yin ĵabsar-tur aĵiraγuluγdaqui:

ene miq-a čisun-u ulayan baling-i amsan soyurq-a:

dzambudvib-un ene idegen-i amsan soyurq-a:

rakta-yin em-ún ene takil-i amsan soyurq-a:

dzagad³²⁷ bayatur em-ún ene takil úres-i amsan soyurq-a:

ariγun ene altan darasun-u degeĵi-yi amsan soyurq-a:

uridu-yin ĵakiraysan ĵokilduγsan-i úlemĵi ačilal-i ergúmú:

edúge ĵakiruγsan-i ĵokilduqui úlemĵi ĵalbaril-i abuγad:

nókód-i sakiγun saγad ĵedker-i qariγul-un

óstú dayisun qoor-tan todqar terigúten

simnus kiged ĵaγur-a oγtaluyči neng olan ĵúil-ten

búgúde-yi barman-u toγosun metú tobaray bolγaγad:

šasin-i delgerekú-i-yin úiles-i či ber bütúgen soyurq-a: (...)

Жоо³²⁸

(...) номын чанарын эрхтэй гагцхүү шимнусын эх³²⁹ - хэмээхээс³³⁰

нохой, чоно, шувуу тэргүүтэн нөхөд лүгээ нэгнээ

урт настай таван эгч дүү суурьтай арван хоёр охин тэнгэр³³¹ хийгээд

орд дэлхийн эзэн догшин нөхөд нэгнээ

дайсны амийг эрхээр болгогч яргачны аймаг:

энд ирээд чимэгт энэ балинг амсан соёрх

³²⁵ Монголоор дүү (то. degüi) гэсэн үгийг энд дүй(düi) хэмээсэн байна.

³²⁶ Төвд bstan ma - эм тэнгэрс

³²⁷ dzagad - хуучин бичгэнд уг үгийг тэр хэвээр нь галиглаж бичдэг ёсон буй. Үүнийг үндэслэн бичсэн болно.

³²⁸ Лхам бурхны зүрхэн тарни

³²⁹ Лхам бурхны өөр нэрс: Nebesky-Wojkowitz: Oracles and Demons. pp. 21–37.

³³⁰ Бүтээх аргын дээр дурдсан хэсгээс үзнэ үү. Жижиг үсэгтэй мөрүүд бол лам нарын хийх зүйлсийн тайлбар болно. Эдгээрийг чангаар унших хэрэггүй.

³³¹ Эдгээр нь бурхдын нөхөр сэлт.

хэмээхээр балиныг умар, дорнын завсарт авчируулах.³³²

энэ мах цусны улаан балинг амсан соёрх
замбутивийн энэ идээг амсан соёрх
ракта-гийн эмийн энэ тахилыг амсан соёрх
загад баатар эмийн энэ тахил үрсийг амсан соёрх
ариун энэ алтан дарсны дээжийг амсан соёрх
урьдын захирсан зохилдсон үлэмж ачлалыг өргөмөй:
эдүгээ захирсан зохилдохуй үлэмж залбирлыг аваад:
нөхдийг сахиун саад зэдгэрийг хариулан
өст дайсан хортон тотгор тэргүүтэн
шимнус(шулмас) хийгээд зуур огтлогч нэн олон зүйлтэн
бүгдийг барманы тоос мэт товрог болгоод
шашныг дэлгэрэхүйн үйлсийг чи бээр бүтээн соёрх. (...)

Дээр тэмдэглэснээр доорхи тахилууд тодорхой болсон. Үүнд:

1. энд ирээд чимэгт балин (тө. 'dir gshegs rgyan gyi gtor ma, мо. ende ireged čimeg-tū baling)
2. мах цусны улаан балин (тө. sha khrag dmar gyi gtor ma, мо. miq-a čisun-u ulayan baling)
3. замбутивийн идээ (тө. 'dzambutiba'i zhal zas, мо. jambudvib-un idegen)
4. ракта-гийн эмийн тахил (тө. sman rag phud kyi mchod pa, мо. rakta-yin em-ūn takil)
5. загад баатар эмийн тахил (тө. dza gad dpa' bo'i sman phud, мо. dzagad bayatur em-n takil úres)
6. ариун алтан дарсны дээж (тө. gtsang ma phud kyi gser skyems, мо. ariyun altan darasun-u degeji)

ДҮГНЭЛТ


Данраг тахил нь тус тахилын зүйлүүдийг бурханд ачлал дамжуулахаас гадна өөрийнхөө хүслийг тодорхойлж, бурхнаас сайн сайхныг хүсэж, дайсныг дарж, шашныг хамгаалах тухайд уншдаг.

Шалгасан төвд дүмта дагуу Лхам бурхны энэ тахилга бол IV Банчин лам Лувсанчойжигжалцан (1570-1662) зохион бичсэн бололтой.

Цэдэрийн данраг шинэ жилдээ сайн сайхан бүхэн дэлгэрч байхыг бэлэгдсэн бэлэгдлийн утга санаатай. Жайв данраг, Чойжоогын данрагын өргөл нь Цэдэрлхамтай адил боловч, унших судар ном болон балингууд нь өөр өөр байдаг.


³³² Шамнах лам тахилуудыг нэг нэгээр өргөж, харин туслагч нар өргөсөн тахилуудыг нэг нэгээр нь гадагш нь авч гарна.

ХАВСРАЛТ



The Baling Offerings


1. Pozdneyev, A. M.: Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia. Ed: Krueger, John R. The Mongolia Society, Bloomington 1978. p. 422.



2. Цагаан човомбо Лувсаннамжил: Vla ma yi dam rdo rje chos skyong nams kyi gtor ma'i dpe ris sna tshogs bzhugs so. Улаанбаатар, р. 16.



3. Жайв данраг, Зүүн хүрээ Дашчойлин хийд, Улаанбаатар 2004.



4. Цэдэрий данраг, Зүүн хүрээ Дагшчойлингийнхид, Улаанбаатар 2005.

བསྐྱོན་པ་རྒྱས་པའི་ལས་འདི་ཚུད་ཀྱིས་སྐྱབས། (...)

5. данраг судай үсгээр

НОМ ЗҮЙ

1. *Bod rgya tshig mdzod chen mo 1-3*. Mi rigs dpe skrun khang. Peking 1984
2. Das, Sarat Chandra: *A Tibetan-English Dictionary*. Calcutta 2000/1902¹
3. *'Dod khams dbang phyug ma dMag zor rgyal mo'i sgrub thabs gtor chog bzhugs so/ Csoma-hagyatek*, 21. Tib. 525 /32
4. *rGyas pa'i gtang rag 'bul ba'i tshul bzhugs so/ MTA*. Tib. 532/7
5. *dGe bshes Chos kyi grags pas brtsam pa'i brda dag ming tshig gsal ba bzhugs so*. Mi rigs dpe skun khang. Peking. 1987
6. Kara Gyorgy: *The Mongol and Manchu Manuscripts and Blockprints of the Hungarian Academy of Sciences*. Bibliotheca Orientalis Hungarica XLVII. Akademiai Kiado, Budapest 2000
7. *Yamandaga Maqagala Erlig qayan Ókin tngri dörben doysin sudur-un orosiba: MTA*. Mong. 81.
8. Kowalewski, Joseph Étienne: *Dictionnaire mongol-russe-francais*, Kazan, 1844, 1846, 1849
9. Lessing, F. D.: *A Mongolian-English Dictionary*, The Mongolia Society, Bloomington, 1995

10. Luwsannamjil (Blo bzang nam rgyal): *Bla ma yi dam rdo rje chos skyong rnam kyi gtor ma'i dpe ris sna tshogs bzhugs so*, Улаанбаатар
11. Majer Zs.: A Comparative Study of the Ceremonial Practice in Present-Day Mongolian Monasteries, ELTE University, Budapest 2008 (PhD Dissertation)
12. Majer Zs. - Teleki K., Mongol-tibeti halaado aldozat (*danrag*) a haragvo istensegeknek. In: Birtalan A., Kelenyi B., Szilagyi Zs. (szerk), Oseink nyoman Belso-Azsiaban IV, Vedelmezo Istensegek es demonok Mongoliaban es Tibetben. L'Harmattan, Budapest 2010, pp. 39-63.
13. Nebesky-Wojkovitz, René De: *Oracles and Demons of Tibet: The Cult and Iconography of the Tibetan Protective Deities*, 'S-Gravenhage: Mouton, (Tiwari's Pilgrims Book House, Kathmandu Repr. 1993)
14. Orosz G.: *A Catalogue of the Tibetan Manuscripts and Block Prints in the Library of the Hungarian Academy of Sciences. Vol 1.* Budapest 2008
15. Pozdneyev, A. M.: *Religion and Ritual in Society: Lamaist Buddhism in late 19th-century Mongolia*. Ed.: Krueger, J. R. The Mongolia Society, Bloomington 1978
16. Сэрээтэр, Р.: Дагинасыг баясагч дунгийн эгшиг. Улаанбаатар 2002,
17. Sumatiratna: *Bod hor gyi brda yig ming tshig don gsum gsal bar byed pa'i mun sel sgron me* (Corpus Scriptorum Mongolorum VI., VII.) Ulaanbaatar 1959
18. Сүхбаатар, О.: Монгол хэлний харь үгийн толь, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн. Улаанбаатар 1997
19. Terjék József: *Collection of Tibetan MSS and Xylographs of Alexander Csoma de Koros*. Keleti Tanulmányok. MTA. Budapest 1976
20. www.rangjung.com/ry-dic.htm

SUMMURY

The present article entitled "Thanksgiving Offering at the Lunar New Year" describes a special ritual performed in Mongolian Buddhist monasteries at the Lunar New Year. After listing the different types of thanksgiving offering (danrag, Tib. gtang rag), the performance of Tsederiin danrag (T. tshes gtor gyi dan rag) dedicated to Śrīdevī (Baldan Ikham, Tib. Dpal ldan lha mo) at the New Year'Eve is described. The offered goods are listed with their Mongolian, Tibetan, and Sanskrit names, and Tibetan and Mongolian sutras are examined to find the origin of the ritual. Though one of the aims of the thanksgiving is to thank Śrīdevī's support of the year passed, another aim is to encourage her to maintain this support helping the monastery, the monks, and all sentient beings in the New Year as well. It seems that the ritual related to Śrīdevī was first written by the 4th Panchen Lama, Lobsang Chökyi Gyaltsen (T. Blo bzang chos kyi rgyal mtshan, 1570-1662).